СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлсан төсөл, хөтөлбөрүүдийн 2024–2025 оны хэрэгжилт, үр дүн

Аудитын код: ДА-2026/13/УА

Сүхбаатар, 2026 он

Агуулга	Хуудасны дугаар
Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилго, хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
1. Ерөнхий мэдээлэл	4–5
2. Аудитын үр дүн	6–19
3. Аудитаар илрүүлсэн асуудал	19–23
4. Аудитаар илрүүлсэн зөрчил	23
5. Дүгнэлт	23–24
6. Зөвлөмж	25–26
7. Ашигласан эх сурвалж	26–27

Товчилсон үгийн жагсаалт

АБ	Ажлын баримт
АХТ	Арга хэмжээний төлөвлөгөө
БГ	Боловсролын газар
БОГ	Байгаль орчны газар
БОНХОБТХ	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ГТ	Гүйцэтгэлийн төлөвлөгөө
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДАОУС	Дотоод аудитын олон улсын стандарт (IIA, Global Internal Audit Standards, 2024)
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗД	Засаг дарга
ЗДҮАХ	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
мянган₮	мянган төгрөг
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
сая₮	сая төгрөг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СУАЖЗГ	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
СХШУАБ	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХАА	Хөдөө аж ахуй
ХЖТ	Хөгжлийн жилийн төлөвлөгөө
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХШҮХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн товъёг

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан ИТХ-ын хөтөлбөрүүд, хариуцагч нэгж	5
Хүснэгт 2	Хөтөлбөрүүдийн 2025, 2026 оны ХЖТ-ийн төлөвлөсөн хөрөнгө, 2025 оны төсөв, гүйцэтгэл ба Засаг даргын үйл ажиллагааны дансны зарцуулалт	8-10
Хүснэгт 3	Хөтөлбөрүүдийн 2025 оны хэрэгжилтийн тайлагнал	12
Хүснэгт 4	Аймгийн ЗДҮАХ 2025–2028-ийн хугацаанд ИТХ-аар батлуулахаар тусгасан хөтөлбөрийн нэгтгэл, бүлгээр	14
Хүснэгт 5	Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан хөтөлбөрүүдийн батлагдсан он, хэрэгжилтийн шат	15
Хүснэгт 6	Аймгийн ЗДҮАХ-д ИТХ-аар батлуулж хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн нэгдсэн мэдээлэл	15-17
Хүснэгт 7	Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан хөтөлбөрийн нэгтгэл, төрөл ба бүлгээр	17-18
Хүснэгт 8	ИТХ-аар баталсан ЗДҮАХ (16/2025) болон 6 хөтөлбөр, бодлогын баримт бичгийн боловсруулалтын үнэлгээ	19
Хүснэгт 9	Илэрсэн асуудал, шийдвэрлэлтийн нэгтгэл	24
Хүснэгт 10	Зөвлөмж хүргүүлэх байгууллага, үндэслэл	27

АУДИТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын (ЗГ) 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан «Дотоод аудитын дүрэм», Дотоод аудитын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын баталсан ДА-2026/13/ҮА дугаартай удирдамж.
Аудитын зорилго:	«Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсөл, хөтөлбөрүүдийн 2024–2025 оны хэрэгжилт, үр дүн»-г үнэлж, илэрсэн зөрчлийг арилгах, хөтөлбөрийн төлөвлөлт, санхүүжилт, тайлагнал, хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлагыг сайжруулах зөвлөмж өгөх.
Аудитын хамрах хүрээ:	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас (ИТХ) баталсан төсөл, хөтөлбөрүүдийн 2024–2025 оны хэрэгжилтийн явц, үр дүн: ИТХ-ын Тэргүүлэгчдийн 84/2020; ИТХ-ын 102/2023; 13/2024; 16, 44, 53, 57, 58, 59/2025; 75, 76, 77, 110, 111, 122/2026 дугаар тогтоол, Засаг даргын (ЗД) үйл ажиллагааны хөтөлбөр (ЗДҮАХ) 2021–2024, 2025–2028 болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (АХТ, А/122), хөгжлийн жилийн төлөвлөгөө (ХЖТ) 2024, 2025, ЗДҮАХ-ийн зардлаас 2025 онд санхүүжүүлсэн 24 захирамжийн (217.7 сая₮)

	Засаг даргын үйл ажиллагааны дансны журналтай тулгалт болон ЗДҮАХ-ийн зардлаас санхүүжилт олгосон 164 захирамжийн ЗДҮАХ-ийн заалтын тулгалт. 2026 онд батлагдсан тогтоолуудыг 2025 оны ХЖТ, ЗДҮАХ-ийн тайланд хувиар тайлагнасан, заримд нь 2025 онд санхүүжилт олгосон тул хамруулав. Удирдамжийн 4-т заасны дагуу 2024 оноос өмнөх хэрэгжилт, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 121/2021 тогтоолоор арга хэмжээ хэлбэрээр баталсан «Чадварлаг багш»-ийг хамруулаагүй. ИТХ-ын 120/2023 тогтоолоор «Сүрьеэгүй Сэлэнгэ-2»-ыг арга хэмжээ хэлбэрээр баталсан тул хөтөлбөрийн тоонд оруулаагүй; ИТХ-ын 13/2024, 44/2025 тогтоолоор баталсан баримт бичгийг бодлогын баримт бичиг гэж ангилав. ИТХ-ын үйл ажиллагаа аудитын хамрах хүрээнд хамаарахгүй.
Аудитын арга зүй, стандарт:	Дотоод аудитын олон улсын стандарт (ДАОУС, 2024): 13.2 (даалгаврын эрсдэлийн үнэлгээ), 13.3–13.4 (зорилго, хамрах хүрээ, үнэлгээний шалгуур), 14.1–14.6 (мэдээлэл цуглуулах, шинжилгээ, илрүүлэлтийг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт, баримтжуулалт), 15.1 (эцсийн тайлагнал), 15.2 (зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулах); Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан аргачлал, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026.02.12-ны А/06 тушаалаар баталсан ажлын баримтын загвар. Арга техник: асуулга, баримт тулгалт, эрсдэл-хяналтын матриц (ажлын баримт буюу АБ-2003), үндсэн шалтгааны шинжилгээ (5 яагаад), биет үзлэг.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоол, ИТХ-ын тогтоол, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, Засаг даргын Тамгын газрын (ЗДТГ) Эрсдэлийн удирдлагын журам (2018).
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч (СХШУАБ) Т.Одсүрэн (багийн ахлагч), дотоод аудитор Г.Дорждэрэм, Б.Идэрчулуун нар 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 2026 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд.

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Аудитын үндэслэл ба зорилго

Аймгийн Засаг даргын баталсан ДА-2026/13/ҮА дугаартай удирдамж болон Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар «Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлсан төсөл, хөтөлбөрүүдийн 2024–2025 оны хэрэгжилт, үр дүн» сэдэвт гүйцэтгэлийн дотоод аудитыг 2026 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 2026 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд гүйцэтгэв.

Аудитын зорилго нь ИТХ-аар батлсан хөтөлбөрүүд хуулийн шаардлагын дагуу боловсрогдож, санхүүжиж, хэрэгжиж, тайлагнагдаж байгаа эсэхийг үнэлж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгөхөд оршино. ИТХ өөрөө аудитын хамрах хүрээнд хамаарахгүй бөгөөд ИТХ-ын Ажлын албанаас зөвхөн баримтаар тулгах мэдээлэл авсан (АБ-1002).

1.2. Аудитад хамрагдсан хөтөлбөрүүд ба хариуцагч нэгжүүд

Хөтөлбөрийг ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (БОНХОБТХ), Нийгмийн бодлогын хэлтэс (НБХ), Цэргийн штаб боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлдэг, хэрэгжилтийг Засаг даргын харьяа агентлагууд – Боловсролын газар (БГ), Эрүүл мэндийн газар (ЭМГ), Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар (СУАЖЗГ), Биеийн тамир, спортын газар (БТСГ), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (ХХҮГ), Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ), Байгаль орчны газар (БОГ) хангадаг, хяналт-шинжилгээг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (ХШҮХ), санхүүжилтийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (СТСХ) хариуцдаг.

Хүснэгт 1 Аудитад хамрагдсан ИТХ-ын хөтөлбөрүүд, хариуцагч нэгж

Хөтөлбөр	Аймгийн ЗДҮАХ-ийн заалт	Тогтоол №	Огноо	Хугацаа	Санхүүжилт, сая₮	Хариуцагч
I. 2025 оны эцэс гэхэд батлагдсан (6)						
Нутгийн оюутан	2.1.1.14	53	2025.09.30	2025–2028	Жилд 175.0 хүртэл	ЗДТГ, БГ
Багш, сурагч солилцоо	2.1.1.6	57	2025.12.04	2025–2028	Дүнгүй	БГ
Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж-2	2.1.1.9	58	2025.12.04	2025–2028	231.6 (ХЖТ-ийн тайланд; батлагдсан ХЖТ-д дүнгүй)	БГ
Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг	2.2.1.7	59	2025.12.04	2026–2030	Дүнгүй	СУАЖЗГ
Нээлттэй Сэлэнгэ	1.1.4	102	2023.04.12	2023–2030	Дүнгүй	ЗДТГ
Спортлог Сэлэнгэчүүд	2.4.1.1	84	2020.12.25	2020–2028	Дүнгүй	БТСГ
II. 2026 онд батлагдсан (6)						
Сэлэнгэ Органик хүнс	3.3.5	75	2026.01.30	2026–2031	«Нэг суурин»-тай хамт (ХЖТ 2025)	ЗДТГ
Өдөр бүр нэг аяга сүү	2.1.1.15	76	2026.01.30	2026–2027 хичээлийн жил	750.0 (ХЖТ 2025-д төсөвлөсөн)	БГ

Чадварлаг эмч, чадварлаг сувилагч	2.3.2.3	77	2026.01.30	2025–2028	Мэдээлэлгүй	ЭМГ
Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд	4.5.1	110	2026.06.30	2026–2028	22.0 (ХЖТ 2025)	ЗДТГ (Цэргийн штаб)
Орлоготой оюутан	2.1.1.12	111	2026.06.30	2026–2028	109.6	ЗДТГ, БГ, ХХҮГ, СУАЖЗГ
Зохистой хөдөлмөр эрхлэлт	2.6.1.6	122	2026.09.25	2026–2028	10.0 (ХЖТ 2025)	ХХҮГ

Үүнээс гадна аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан орон нутгийн 8 хөтөлбөр («Ногоон Сэлэнгэ», «Хог хаягдлын менежмент», «Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн», «Старт-ап», «Түрээсийн орон сууц», «Сайн багш таны дэргэд», «Соёлын бүтээлч үйлдвэрлэл II», «Иргэний боловсрол») 2026.11.01-ний байдлаар ИТХ-аар батлагдаагүй байна.

1.3. Засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын төлөвшил

Удирдлага, хэлтсүүдээс авсан асуулгаар (АБ-1002–1005) хөтөлбөрийн засаглалын бүтэц, хариуцлагын хуваарилалт III түвшинд, харин дотоод хяналтын бусад элементүүд, мэдээлэл дамжуулалт, мониторинг, эрсдэлийн удирдлага I (эхлэлийн) түвшинд байна. 2018 онд баталсан Эрсдэлийн удирдлагын журмыг шинэчлээгүй байсан бөгөөд шинэ журмыг аудитын явцад буюу 2026.10.28-нд А/47-оор баталсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (ЗГХЭГ) 2025.06.27-ны 02/736 албан бичгээр өгсөн 9 зөвлөмжийн хэрэгжилтийг хэлтсийн дарга, Тамгын газрын дарга хянадаг гэж хариулсан.

Эрсдэлийн урьдчилсан үнэлгээгээр (АБ-1006) аудитын объект «дунд эрсдэлтэй» (11.6 оноо), гүйцэтгэлийн үнэлгээгээр (АБ-3001) эрсдэл бодитоор үүсч, оноо 15.2 болж «дунд эрсдэлтэй (дээд хязгаарт)» түвшинд хүрсэн.

1.4. Аудитын хязгаарлалт

Удирдамжийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оноос өмнөх үеийн хэрэгжилтийг аудитын хамрах хүрээнд оруулаагүй. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗДҮАХ)-ийн 2025–2028 онд хэрэгжүүлэхээр тусгасан хөтөлбөрүүдээс аймгийн ИТХ-аар батлагдсан хөтөлбөрийг аудитад хамруулав. Гуравдагч этгээдээс нотлох баримт цуглуулах боломж хязгаарлагдмал байсан тул хөтөлбөрийн санхүүжилтийн дүнг Засаг даргын захирамж болон Засаг даргын үйл ажиллагааны дансны журналтай тулган шалгав.

2024 оноос өмнө арга хэмжээ хэлбэрээр батлагдсан «Чадварлаг багш» (ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.28-ны 121 дүгээр тогтоол), «Сүрьеэгүй Сэлэнгэ-2» (ИТХ-ын 2023.07.26-ны 120 дугаар тогтоол; аймгийн ЗДҮАХ-ийн 2.3.1.5-д «хөтөлбөр» гэж нэрлэсэн)-ыг хөтөлбөрийн жагсаалт, тоонд оруулаагүй; аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.2, 3.3.1-д заасан бодлогын баримт бичгийг (ИТХ-ын 13/2024, 44/2025) хөтөлбөрийн тоонд оруулаагүй (2.5).

2026 оны хувьд ХЖТ (ИТХ-ын 52/2025 тогтоол), төсвийн (ИТХ-ын 56/2025 тогтоол) хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй тул аудитын явцад 11 дүгээр

сарын байдлаар гаргуулан авсан зарцуулалтыг 2025 оны төлөвлөлт, гүйцэтгэлтэй харьцуулав (Хүснэгт 2). ЗДҮАХ-ийн урсгал зардлаар хөрөнгө бэлтгэсэн асуудал нь ИТХ-ын хөтөлбөрийн хэрэгжилтийн бус, зардлын ангиллын асуудал тул энэ аудитын хүрээнд дүгнээгүй, санхүүгийн аудитаар шалгах нь зүйтэй.

2.АУДИТЫН ҮР ДҮН

Энэ бүлэгт хаалтанд заасан №1–№7 нь 3 дугаар бүлгийн илэрсэн асуудал 3.1–3.7-ийг заана.

2.1. Төлөвлөлт, шийдвэрийн үндэслэл

- **АХТ төсөвгүй:** аймгийн ЗДҮАХ-ийн 2025–2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (А/122) арга хэмжээ тус бүрийн төсөв, эх үүсвэр, жилийн задаргаа байхгүй; аймгийн төсөвт «ЗДҮАХ-ийн хэрэгжилт» бөөн дүнгээр (2025 онд 1,000.0 сая₮) тусгагдсан (№3).
- **ХЖТ хоцорсон:** Аймгийн 2025 оны ХЖТ-г ИТХ-ын 2025.04.10-ны 22 дугаар тогтоолоор батлсан нь хуулийн хугацаанаас (2024.10.01) 6 сар гаруй хугацаагаар хоцорсон (№5).
- **Боловсруулалт:** Хөтөлбөрийн төслийг суурь судалгаанд үндэслэж, ЗД-ын зөвлөлөөр 2 удаа хэлэлцүүлсэн боловч олон нийтийн хэлэлцүүлэг, хууль зүйн дүгнэлт аваагүй (АБ-1003).
- **Төсөвгүй хөтөлбөр:** ИТХ-аар 2024–2025 онд батлсан 2 бодлогын баримт бичиг, 3 хөтөлбөрт (13/2024; 44, 57, 58, 59/2025) санхүүжилтийн зөвхөн эх үүсвэрийг жагсааж, төсвийн дүн, санхүүгийн тооцоолол тусгаагүй (№1). Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний дутагдлыг 2.6-д тусгав.

2.2. Санхүүжилт, зарцуулалт

Хөтөлбөрүүдийн санхүүжилтийн төлөвлөлт, гүйцэтгэлийг аймгийн 2025 оны ХЖТ (ИТХ-ын 2025.04.10-ны 22 дугаар тогтоол), түүний хэрэгжилтийн тайлан (ИТХ-ын 2026.04.30-ны 90 дүгээр тогтоол), 2026 оны ХЖТ (ИТХ-ын 2025.09.30-ны 52 дугаар тогтоол), аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан (ИТХ-ын 89/2026) болон Засаг даргын үйл ажиллагааны 100130051000 дугаар дансны 2025 оны санхүүжилттэй тулгаж харьцуулав (Хүснэгт 2).

Хүснэгт 2Хөтөлбөрүүдийн 2025, 2026 оны ХЖТ-ийн төлөвлөсөн хөрөнгө, 2025 оны төсөв, гүйцэтгэл ба Засаг даргын үйл ажиллагааны дансны зарцуулалт, сая₮

ХЖТ-ийн бүлэг	ЗДҮАХ			Хөгжлийн жилийн төлөвлөгөө 2025 он			Төрийн сангийн 2025 оны санхүүжилт	Хөгжлийн жилийн төлөвлөгөө 2026 он		Тайлбар
	№	Хөтөлбөр, бодлогын баримт бичгийн нэр	ЗДҮАХ-ийн заалт	Батлагдсан төсөв (сая ₮)	зарцуулалт (сая ₮)	Хувь, %		Батлагдсан төсөв (сая ₮)	Зарцуулалт (сая ₮)	
I. Аудитын явцад батлагдсан хөтөлбөр (12)										
Бүсчилсэн хөгжлийн бодлого	1	Нээлттэй Сэлэнгэ	1.1.4	-	-	70	10.6	-	-	ХЖТ-2025 №5; ХЖТ 2026-д хөтөлбөрийн мөрөнд дүнгүй, хүрээнд нь улсын төсвийн 553.9 сая₮-ийн Алтанбулаг чөлөөт бүсийн гаалийн хяналтын арга хэмжээ (дүнд оруулаагүй)
Хүний хөгжлийн бодлого	2	Спортлог Сэлэнгэчүүд	2.4.1.1			–	51.1	250.0	53.0	ХЖТ-д тусгаагүй; ГТ тусгасан
	3	Нутгийн оюутан	2.1.1.14	-	-	100	8.8	175.0	115.0	ХЖТ-2025 №35; 2026 оны 175.0 нь ХЖТ 2026-ийн дүн, үүнээс 23 оюутанд 115.0 сая₮ олгосон; А/291 (0.6 сая₮, 2.1.1.14) ЗДТГ-ын задаргаа, журналд тусдаа гүйлгээгүй тул тооцоогүй
	4	Багш, сурагч солилцоо	2.1.1.6	-	-	100	17.6	20.0	-	ХЖТ-2025 №29
	5	Сургалтын байгууллага–тоног төхөөрөмж 2	2.1.1.9	231.6	-	100	16.8	933.6	104.4	ХЖТ-2025 №47
	6	Сэлэнгэ хувьсгалын өлгий нутаг	2.2.1.7	-	-	70		30.0	-	ХЖТ-2025 №68
	7	Өдөр бүр нэг аяга сүү	2.1.1.15	750.0	-	70		683.5	-	ХЖТ-2025 №36

	8	Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадварлаг эмнэлгийн мэргэжилтэн	2.3.2.3	-	-	70	5.8	18.0	-	ХЖТ-2025 №81; ХЖТ-д 2 мөрөөр (100%, 70%) тайлагнасан
	9	Орлоготой оюутан	2.1.1.12			–		-	-	ХЖТ-д тусгаагүй, зарцуулалтгүй
	10	Зохистой хөдөлмөр эрхлэлт	2.6.1.6	10.0	-	50		-	-	ХЖТ-2025 №107
Эдийн засгийн бодлого	11	Сэлэнгэ Органик хүнс	3.3.5	100.0	19.5	70	46.4	-	-	ХЖТ-2025 №164; А/50, 76, 316, 174, 216; А/174, 216 нь хэд хэдэн заалтад үндэслэсэн захирамж
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	12	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах	4.5.1	22.0	-	30	44.7	35.0	36.9	ХЖТ-2025 №270; А/94, 113, 169, 483 (А/483 нь 4.5.3-т үндэслэсэн, ЗДТГ-ын төрийн санчтай тулгаж хамааруулсан)
Хөтөлбөрийн дүн				**1,113.6**	**19.5**		**201.8**	**2,145.1**	**309.3**	
II. Батлагдаагүй хөтөлбөр (8)										
Хүний хөгжлийн бодлого	13	Сайн багш таны дэргэд	2.1.1.6	-	-	–				ХЖТ-д тусгаагүй; ГТ тусгасан
	14	Соёлын бүтээлч үйлдвэрлэл II	2.2.1.6	-	-	–				ХЖТ-д тусгаагүй; ГТ тусгасан
	15	Старт-ап	2.6.1.4	33.0	30.0	90		33.0	-	ХЖТ-2025 №105
Эдийн засгийн бодлого	16	Ногоон Сэлэнгэ	1.1.13	-	-	–	12.7	-	-	ХЖТ-2025 №192–193 (1.1.13); ХЖТ-д нэрээр тусгаагүй, «Эдийн засаг» бүлэгт; 1.1.13-ын «Тэрбум мод» ажилд 191.0 сая₮ төлөвлөсөн нь 1,146.6-д ороогүй
	17	Түрээсийн орон сууц	3.2.12	-	-	30				ХЖТ-2025 №144

	18	Нэг суурин–Нэг бүтээгдэхүүн	3.3.15	(11-д)	(11-д)	70			-	ХЖТ-2025 №164
	19	Хог хаягдлын менежментийг сайжруулах	3.4.6	-	-	70	3.3	175.0	-	ХЖТ-2025 №202
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	20	Иргэний боловсрол	4.2.1.9	-	-	–		30.0		ХЖТ 2025-д тусгаагүй
Хөтөлбөрийн дүн				**33.0**	**30.0**		**15.9**	**238.0**	**0.0**	
III. Харьцуулалтад: бодлогын баримт бичиг (2)										
Эдийн засгийн бодлого	21	Ногоон хөгжлийн бодлого 2030	–	–	–	50		–	–	Хөрөнгөгүй, 50%
	22	ХАА-г 2030 хүртэл хөгжүүлэх бодлого	–	–	–	100	–	–	–	Хөрөнгөгүй, 100%; A/174 (3.3.2, 3.3.5)-ийг «Органик хүнс»-д (№11) тооцсон
Дүн				**0.0**	**0.0**		**0.0**	**0.0**	**0.0**	
Нийт				**1,146.6**	**49.5**		**217.7**	**2,383.1**	**309.3**	

Эх сурвалж: ИТХ-ын 22/2025 (ХЖТ 2025), 90/2026 (ХЖТ 2025-ийн хэрэгжилт), 52/2025 (ХЖТ 2026) тогтоолын хавсралт; ЗДТГ-ын «Мөрийн хөтөлбөр 2025» захирамжийн задаргаа, Засаг даргын үйл ажиллагааны дансны (100130051000) 2025 оны журнал. ХЖТ 2025-ийн «Батлагдсан төсөв» нь «Нийт хөрөнгийн хэмжээ», «зарцуулалт» нь «Төсөв гүйцэтгэл», «Хувь» нь «Хэрэгжилтийн хувь» багана; «Батлагдсан төсөв», «зарцуулалт»-ыг ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайлангаас авсан бөгөөд «Тоног төхөөрөмж-2»-ын 231.6 сая₮ батлагдсан ХЖТ-д (22/2025) тусгагдаагүй. «Төрийн сангийн 2025 оны санхүүжилт»-д тухайн хөтөлбөрийн ЗДҮАХ-ийн заалтад үндэслэсэн захирамжийн дүнг тооцов; үүнээс ЗДҮАХ-ийн бусад заалтад мөн үндэслэсэн 6 захирамжийг (53.5 сая₮; A/54, A/174, A/192, A/216, A/472, A/477) зөвхөн нэг хөтөлбөрт хамааруулав. «–» – мөр байгаа боловч дүн тусгаагүй; «ТГ» – тусгаагүй. «ХЖТ-2025 №» нь ЗДТГ-ын ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайлангийн «Д/д» дугаар. Төрийн сангийн санхүүжилтийн 217.7 сая₮-ийг Засаг даргын үйл ажиллагааны дансны журналаар ЗДТГ-ын төрийн санчтай тулгаж баталгаажуулсан. «Хувь» баганыг ИТХ-ын 90/2026 тогтоолын хавсралтаар тусгав. Дүнг төгрөгөөр нэмж, сая₮-өөр бөөрөнхийлсөн тул нийлбэрт ±0.1 сая₮-ийн зөрүү гарч болно.

Аймгийн 2025 оны ХЖТ (22/2025) болон хэрэгжилтийг (90/2026) тулгахад «Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж-2»-т батлагдсан ХЖТ-д санхүүжилт тусгаагүй атлаа хэрэгжилтийн тайланд 231.6 сая₮ төлөвлөсөн мэтээр тусгажээ. 2025 оны ХЖТ-д ЗДҮАХ-д ИТХ-аар батлуулахаар тусгасан 20 хөтөлбөрийн 13-ыг нэрээр нь, 2-ыг холбогдох заалтаар («Тэрбум мод» 1.1.13, залуучуудын гарааны бизнес 2.6.1.4) тусгаж, 5-ыг («Спортлог Сэлэнгэчүүд», «Орлоготой оюутан», «Сайн багш таны дэргэд», «Соёлын бүтээлч үйлдвэрлэл II», «Иргэний боловсрол») тусгаагүй.

Батлагдсан төсөв, хэрэгжилтийн хувь ба зарцуулалтыг харьцуулахад ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайланд (90/2026) 6 хөтөлбөрт нийт 1,146.6 сая₮-ийн хөрөнгө (ЗДҮАХ-ийн 1.1.13-ын «Тэрбум мод» ажлын 191.0 сая₮-ийг оруулаагүй) төлөвлөснөөс зөвхөн 2 хөтөлбөрт («Органик хүнс» 19.5, «Старт-ап» 30.0) 49.5 сая₮ буюу 4.3%-ийн гүйцэтгэл тайлагнасан. Гэтэл «Өдөр бүр нэг аяга сүү» (750.0 сая₮, гүйцэтгэл 0) 70%, «Тоног төхөөрөмж-2» (231.6, гүйцэтгэл 0) 100%, «Зохистой хөдөлмөр эрхлэлт» (10.0, гүйцэтгэл 0) 50%, «Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд» (22.0, гүйцэтгэл 0) 30%, «Органик хүнс» (100.0, гүйцэтгэл 19.5) 70% гэж үнэлсэн. Мөн хөрөнгө, гүйцэтгэл огт тусгаагүй 7 хөтөлбөрийн хэрэгжилтийг 30–100% («Нутгийн оюутан», «Багш, сурагч солилцоо» 100%; «Нээлттэй Сэлэнгэ», «Хувьсгалын өлгий нутаг», «Чадварлаг эмч», «Хог хаягдал» 70%; «Түрээсийн орон сууц» 30%) гэж, «Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн»-ийг «Органик хүнс»-тэй нэг мөрөөр 70% гэж үнэлсэн. Зөвхөн «Старт-ап»-ын 90% нь гүйцэтгэлтэй (90.9%) нийцэж байна. Иймд хэрэгжилтийн хувь нь санхүүжилтийн гүйцэтгэлтэй уялдаагүй, үндэслэлгүй тайлагнагдсан (№3, №4).

ЗДҮАХ-ийн хүрээнд 2025 онд Засаг даргын үйл ажиллагааны 100130051000 дугаар данснаас 981.9 сая₮ зарцуулсан (Төрийн сангийн 2025 оны төсвийн тайлан, хөтөлбөр 81518), үүнээс ИТХ-ын хөтөлбөрт хамаарах ЗДҮАХ-ийн заалтад үндэслэсэн 24 захирамжаар (4.5.3-т үндэслэсэн А/483-ыг Төрийн санчтай тулгаж хамааруулсан) 217.7 сая₮ (22.2%) олгосон байна. Харин үлдсэн 764.2 сая₮ (77.8%) нь бусад арга хэмжээнд зарцуулсан байна. ИТХ-ын хөтөлбөрт олгосон 217.7 сая₮-ийн 171.3 сая₮ буюу 78.7 хувь нь ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайланд гүйцэтгэл тайлагнаагүй 9 хөтөлбөрт («Спортлог Сэлэнгэчүүд» 51.1, «Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд» 44.7, «Багш, сурагч солилцоо» 17.6, «Тоног төхөөрөмж-2» 16.8, «Ногоон Сэлэнгэ» 12.7, «Нээлттэй Сэлэнгэ» 10.6, «Нутгийн оюутан» 8.8, «Чадварлаг эмч» 5.8, «Хог хаягдал» 3.3 сая₮), үлдсэн 46.4 сая₮ нь «Органик хүнс»-д ногдож байгаа нь ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайланд тусгасан 19.5 сая₮-ийн гүйцэтгэлээс 26.9 сая₮-өөр их байна. Харин ХЖТ 2025-д хамгийн их хөрөнгө (750.0 сая₮) төлөвлөсөн «Өдөр бүр нэг аяга сүү»-д Засаг даргын үйл ажиллагааны данснаас гүйлгээ гараагүй, «Старт-ап»-ын тайлагнасан 30.0 сая₮-ийн гүйцэтгэл Засаг даргын үйл ажиллагааны данснаас бус өөр эх үүсвэрээс санхүүжсэн байна. Иймд ХЖТ-ийн «Төсөв», «Гүйцэтгэл» баганыг хөтөлбөрийн бодит санхүүжилттэй уялдуулж бөглөөгүй тул ХЖТ-ийн тайлангаар хөтөлбөрийн зардал, үр ашгийг хянах боломжгүй байна.

Аймгийн төсөвт ЗДҮАХ-ийн зардлыг «Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт» нэрээр хөтөлбөр, арга хэмжээгээр задлалгүй бөөн дүнгээр

2024 онд 1,228.0 сая₮ (ИТХ-ын 2024.09.23-ны 180 дугаар тогтоол, тодотгол), 2025 онд 1,000.0 сая₮ (2025.09.16-ны 43 дугаар тогтоол, тодотгол), 2026 онд 2,600.0 сая₮ (2025.12.04-ний 56 дугаар тогтоол) баталжээ. Иймээс 2025 онд уг зардлаас зарцуулсан 981.9 сая₮-ийн 217.7 сая₮ (22.2%)-ийг л ИТХ-ын хөтөлбөртэй заалтаар нь холбож тооцох боломжтой байв (Хүснэгт 2). 2026 онд уг зардлаас 2,099.6 сая₮ зарцуулсан байна (аудитын хугацаанд авсан Төрийн сангийн 2026 оны төсвийн тайлан, хөтөлбөр 81518). 2026 оны төсвийг баталсан ИТХ-ын 56/2025 тогтоолын нэгдүгээр хавсралтын (хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт) 15.1-д ЗДҮАХ-ийн хугацааг «2026–2030» гэж буруу бичиж, шалгуур үзүүлэлтийг зөвхөн «хувь – 100» гэж тусгасан тул 2,600.0 сая₮-ийг аль хөтөлбөрт хэдийг зарцуулахыг тодорхойлоогүй, ХЖТ 2026-д төлөвлөсөн санхүүжилт төсвөөр баталгаажсан эсэхийг тогтоох боломжгүй байна. Төрийн аудитын байгууллага 2024 оны нэгтгэсэн тайлангийн аудитаар ЗДҮАХ-ийн төсвөөс 413.6 сая₮-ийг техник, тоног төхөөрөмж, хөрөнгө худалдан авах болон бусад урсгал зардалд зарцуулсныг Төсвийн тухай хуулийн 6.4.1-ийг зөрчсөн гэж үзэж албан шаардлага хүргүүлсэн бол 2025 оны аудитын тайланд ЗДҮАХ-ийн зарцуулалтын талаар тусгайлан дүгнээгүй байна (№1, №3).

2.3. Хэрэгжилт ба тайлагнал

Хүснэгт 3 Хөтөлбөрүүдийн 2025 оны хэрэгжилтийн тайлагнал, %

Хөтөлбөр	Тогтоол	ЗДТГ: ХЖТ / YAX	ИТХ 90/2026	Тайлбар
I. 2025 оны эцэс гэхэд батлагдсан (6)				
Нутгийн оюутан	53/2025	100 / 100	100	2025 онд хөтөлбөрийн тэтгэлэг олгоогүй (батлагдахаас өмнө 2.1.1.14-ээр 8.8 сая₮ олгосон)
Багш, сурагч солилцоо	57/2025	70 / 100	100	2025.12.04-нд батлагдсан; ИТХ-ын 90/2026-д ЗДТГ-ын ХЖТ-ийн тайлангаас 30 хувийн нэгжээр өндөр үнэлсэн
Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж-2	58/2025	100 / 100	100	2025.12.04-нд батлагдсан, төсөвгүй
Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг	59/2025	70 / 100	70	2025 онд хэрэгжих арга хэмжээгүй
Нээлттэй Сэлэнгэ	102/2023	70 / 70	70	Нотлох баримт дутуу
Спортлог Сэлэнгэчүүд	84/2020*	– / 100	–	ХЖТ 2025-д тусгаагүй
II. 2026 онд батлагдсан (6), 2025 онд батлагдаагүй байхад хувиар тайлагнасан				
Сэлэнгэ Органик хүнс	75/2026	70 / 70	70	«Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн»-тэй нэг мөрөөр
Өдөр бүр нэг аяга сүү	76/2026	70 / 30	70	Нэг хөтөлбөрийг 2 тайланд өөр хувиар
Чадварлаг эмч, чадварлаг сувилагч	77/2026	100; 70 / 70	100; 70	2025 онд батлагдаагүй
Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд	110/2026	30 / 30	30	ГТ-ний биелэлтэд «батлагдсан», 100%
Орлоготой оюутан	111/2026	– / 90	–	ХЖТ 2025-д тусгаагүй; 2025 онд хэрэгжилтгүй
Зохистой хөдөлмөр эрхлэлт	122/2026	50 / 50	50	2025 онд хэрэгжилтгүй

Хүснэгт 3-т тусгасан ИТХ-аар баталсан орон нутгийн 12 хөтөлбөрөөс 2025.12.04 болон 2026 онд батлагдсан 9 хөтөлбөрийг 2025 онд 30–100% гэж үнэлж, 6 хөтөлбөрийн хэрэгжилтийг ХЖТ, YAX-ийн тайланд зөрүүтэй хувиар үнэлсэн эсвэл аль нэгэнд нь тусгаагүй байна (№4).

2.4. Хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлага

Хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) 2024, 2025 оны тайланд зөвхөн үндэсний шийдвэрүүдийн хэрэгжилт хамрагдаж, ИТХ-ын тогтоол, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн хэсэг байхгүй; ХЖТ 2024-ийн №121-д «8 дэд хөтөлбөрт ХШҮ хийнэ» гэж 70% үнэлсэн боловч хийгээгүй (№6). Эрсдэлийн бүртгэлийн №21 «ИТХ-ын хөтөлбөр төсөвгүйгээс хэрэгжилт муу» эрсдэлд төлөвлөсөн хариу арга хэмжээ хэрэгжээгүй (№7). Хөтөлбөрөөр олж авсан хөрөнгийн бүртгэл, биет үзлэгт (2026.11.03–04) ноцтой зөрүү илрээгүй.

2.5. Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан хөтөлбөрүүдийн батлалт, хэрэгжилтийн явц

ИТХ-ын 2025 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн ЗДҮАХ 2025–2028-д нийт 35 хөтөлбөр, бодлогын баримт бичгийг тусгасан бөгөөд төрлөөр нь ангилбал хөтөлбөр 23 (үндэсний 2, салбарын 1, орон нутгийн 20), бодлогын баримт бичиг 12 (үндэсний 3, салбарын 5, орон нутгийн 4) байна; үүнээс гадна ИТХ-аар арга хэмжээ хэлбэрээр батлагдсан 1 («Сүрьеэгүй Сэлэнгэ-2») баримт бичиг бий. ЗДҮАХ-ийн бүлгээр Бүсчилсэн хөгжилд 4, Хүний хөгжилд 21, Эдийн засагт 7, Засаглалд 3 баримт бичиг хамаарна (Хүснэгт 7). Үүнээс ИТХ-аар батлуулах шаардлагатай нь орон нутгийн 20 хөтөлбөр болон орон нутгийн бодлогын баримт бичиг бөгөөд үндэсний, салбарын баримт бичгийг УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч, салбарын яам баталдаг.

Баримт бичгийн төрлийг баталсан шийдвэрээр нь тогтоов. Аймгийн ЗДҮАХ-ийн 2.3.1.5-д «“Сүрьеэгүй Сэлэнгэ-2” хөтөлбөрийн хүрээнд ... хамруулна» гэж хэрэгжүүлэх заалт тусгасан боловч ИТХ-ын 2023.07.26-ны 120 дугаар тогтоол «“Сүрьеэгүй Сэлэнгэ-2” арга хэмжээ батлах тухай» нэртэй, хавсралт нь «арга хэмжээ», хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө хэлбэртэй байна. Иймд үүнийг хөтөлбөрийн жагсаалтад бус, ИТХ-аар баталсан арга хэмжээ гэж ангилав (аймгийн ЗДҮАХ-д «Гадаад хэлтэй Сэлэнгэ» мөн «арга хэмжээ» гэж тусгасан); мөн 2023 онд батлагдсан тул удирдамжийн 4-т заасан хязгаарлалтад хамаарна. Аймгийн ЗДҮАХ-ийн 1.1.2-т «Ногоон хөгжлийн бодлого 2030» бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, 3.3.1-д «Хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэх бодлогын баримт бичиг»-ийг боловсруулан хэрэгжүүлэхээр заасан тул ИТХ-ын 13/2024, 44/2025 тогтоолоор баталсан баримт бичгийг хөтөлбөр гэж тооцоогүй, орон нутгийн бодлогын баримт бичиг гэж ангилсан бөгөөд ИТХ-ын шийдвэр тул боловсруулалт, санхүүгийн тооцооны үнэлгээнд (2.6, 3.1) хамруулав.

Аудитын сэдэв дэх «2024–2025 оны хэрэгжилт, үр дүн»-г аймгийн ЗДҮАХ-д ИТХ-аар батлахаар тусгасан хөтөлбөрүүдийн аудитын явцад (2026.11.01-ний байдлаар) батлагдсан тоо, түүнээс 2024, 2025 онд батлагдсан хөтөлбөрүүдийн хэрэгжилт ямар шатанд явж байгаагаар тайлагнав. Аймгийн ЗДҮАХ-ийн хугацаанд ИТХ-аар батлах 20 хөтөлбөрийн 12 нь (60.0%) аудитын явцад батлагдсан, 8 нь (40.0%) батлагдаагүй байна. Батлагдсан 12 хөтөлбөрийн 2 нь 2024 оноос өмнө, 4 нь 2025 онд, 6 нь 2026 онд батлагдсан (Хүснэгт 4, 5).

Хүснэгт 4 Аймгийн ЗДҮАХ 2025–2028-ийн хугацаанд ИТХ-аар батлуулахаар тусгасан хөтөлбөрийн нэгтгэл, бүлгээр

Аймгийн ЗДҮАХ-ийн бүлэг	Нийт	Батлагдсан	Батлагдаагүй	Хувь, %	Батлагдсан хөтөлбөр (ИТХ-ын тогтоол)	Батлагдаагүй хөтөлбөр
1. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	1	1	50.0	Нээлттэй Сэлэнгэ (102/2023)	Ногоон Сэлэнгэ
2. Хүний хөгжлийн бодлого	12	9	3	75.0	Нутгийн оюутан (53/2025); Багш, сурагч солилцоо (57/2025); Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж-2 (58/2025); Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг (59/2025); Спортлог Сэлэнгэчүүд (Тэргүүлэгчдийн 84/2020); Өдөр бүр нэг аяга сүү (76/2026); Чадварлаг эмч, чадварлаг сувилагч (77/2026); Орлоготой оюутан (111/2026); Зохистой хөдөлмөр эрхлэлт (122/2026)	Сайн багш таны дэргэд; Соёлын бүтээлч үйлдвэрлэл II; Старт-ап
3. Эдийн засгийн бодлого	4	1	3	25.0	Сэлэнгэ Органик хүнс (75/2026)	Түрээсийн орон сууц; Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн; Хог хаягдлын менежмент
4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	2	1	1	50.0	Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд (110/2026)	Иргэний боловсрол
Бүгд	**20**	**12**	**8**	**60.0**		

Батлагдсан 12 хөтөлбөрийн 2 нь 2024 оноос өмнө («Спортлог Сэлэнгэчүүд» – ИТХ-ын Тэргүүлэгчдийн 84/2020, «Нээлттэй Сэлэнгэ» – 102/2023), 4 нь 2025 онд (53, 57, 58, 59/2025), 6 нь 2026 онд (75, 76, 77, 110, 111, 122/2026) батлагдсан (Хүснэгт 5, 6). 2024 оноос өмнө батлагдсан 2 хөтөлбөр хүчинтэй, 2025 онд хэрэгжиж байсан боловч «Нээлттэй Сэлэнгэ», «Спортлог Сэлэнгэчүүд»-д тогтоолд заасан арга хэмжээний төлөвлөгөө, 2 жил тутмын тайлан ирүүлээгүй, «Спортлог Сэлэнгэчүүд»-ийг ХЖТ 2025-д тусгаагүй. 2025 онд батлагдсан 4 хөтөлбөр бүгд 9–12 дугаар сард батлагдсан бөгөөд 2025 оноос хэрэгжихээр заасан 3 нь (53, 57, 58/2025) 2025 онд хэрэгжээгүй, 2026 оноос хэрэгжиж эхэлсэн, 1 нь (59/2025) 2026 оноос хэрэгжихээр заасан тул эхний шатандаа байна. Өөрөөр хэлбэл 2025 онд хүчин төгөлдөр байсан 6 хөтөлбөрөөс 2025 онд санхүүжилт авч хэрэгжиж байсан нь 2 (33.3%) бөгөөд бүгд 2024 оноос өмнө батлагдсан хөтөлбөр; 2025 онд батлагдсан 4 хөтөлбөрийн аль нь ч 2025 онд хэрэгжээгүй. 2026 онд батлагдсан 6 хөтөлбөрийн хэрэгжилтийг ЗДТГ 2025 оны тайландаа батлагдаагүй байхад нь 30–100% гэж тайлагнасан (Хүснэгт 3, №4); 77/2026-д хэрэгжих хугацааг 2025 оноос буцаан тогтоосон. Батлагдаагүй 8 хөтөлбөрийн бүгдийг мөн 2025 онд ХЖТ эсвэл ҮАХ-ийн тайланд 30–100% гэж тайлагнасан. Мөн одоо хүртэл батлагдаагүй «Старт-ап» (33.0), «Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн»

(«Органик хүнс»-тэй нэг мөрөөр, 100.0) болон 2026 онд батлагдсан «Өдөр бүр нэг аяга сүү» (750.0) хөтөлбөрт батлагдахаас нь өмнө ХЖТ 2025-д нийт 883.0 сая₹ төсөвлөсөн байна. Нийтдээ 2025 онд хэрэгжээгүй болон батлагдаагүй 18 хөтөлбөрийн бүгдийг 30–100% гэж тайлагнасан байна.

Хүснэгт 5 Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан хөтөлбөрүүдийн батлагдсан он, хэрэгжилтийн шат (аудитын явцын байдлаар)

Ангилал (2026.11.01-ний байдлаар)	Тоо	Хувь, %	Хүснэгт 6-гийн мөр
Аймгийн ЗДҮАХ-ийн хугацаанд ИТХ-аар батлах орон нутгийн хөтөлбөр, бүгд	**20**	**100.0**	**1–20**
I. Аудитын явцад батлагдсан	**12**	**60.0**	**1–12**
А. 2024 оноос өмнө батлагдсан, хүчинтэй	2	10.0	1–2
2025 онд хэрэгжиж байсан	2		1–2
Б. 2025 онд батлагдсан	4	20.0	3–6
2025 онд хэрэгжээгүй, 2026 оноос хэрэгжиж эхэлсэн	3		3–5
хэрэгжих хугацаа 2026 оноос эхэлсэн (эхний шат)	1		6
В. 2026 онд батлагдсан (2024–2025 оны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй)	6	30.0	7–12
II. Батлагдаагүй	**8**	**40.0**	**13–20**
үүнээс боловсруулж буй, ИТХ-д өргөн барьсан	2		17, 19
үүнээс ИТХ-д өргөн бариагүй (2 нь ХЖТ-ээр хэсэгчлэн хэрэгжиж буй)	6		13–16, 18, 20

Хүснэгт 6 Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д ИТХ-аар батлуулж хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн нэгдсэн мэдээлэл

№	Хөтөлбөр	Аймгийн ЗДҮАХ-ийн заалт	Тогтоол №	Огноо	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийн шат	ЗДТГ-ын тайлагнасан хувь, 2025 (ХЖТ / ҮАХ)
I. АУДИТЫН ЯВЦАД АЙМГИЙН ИТХ-ААР БАТЛАГДСАН ХӨТӨЛБӨР (12)							
А. 2024 оноос өмнө батлагдсан, хэрэгжих хугацаа дуусаагүй (2)							
1	Спортлог Сэлэнгэчүүд	2.4.1.1	84*	2020.12.25	2020–2028	Хэрэгжиж буй; ХЖТ 2025-д тусгаагүй; арга хэмжээний төлөвлөгөө, 2 жил тутмын тайлан ирүүлээгүй	– / 100
2	Нээлттэй Сэлэнгэ	1.1.4	102	2023.04.12	2023–2030	Хэрэгжиж буй; арга хэмжээний төлөвлөгөө, 2 жил тутмын тайлан ирүүлээгүй; нотлох баримт дутуу	70 / 70
Б. 2025 онд батлагдсан (4)							

3	Нутгийн оюутан	2.1.1.14	53	2025.09.30	2025–2028	2025 онд хэрэгжээгүй (хөтөлбөрийн тэтгэлэг олгоогүй; батлагдахаас өмнө ЗДҮАХ-ийн 2.1.1.14-ээр 3 захирамжаар 8.8 сая₮ олгосон); 2026 онд 23 оюутанд 115.0 сая₮ олгож хэрэгжиж эхэлсэн	100 / 100
4	Багш, сурагч солилцоо	2.1.1.6	57	2025.12.04	2025–2028	2025.12.04-нд батлагдсан тул 2025 онд хэрэгжээгүй; 2026 оноос хэрэгжиж эхэлсэн	70 / 100
5	Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж-2	2.1.1.9	58	2025.12.04	2025–2028	2025.12.04-нд батлагдсан тул 2025 онд хэрэгжээгүй; 2026 оноос хэрэгжиж эхэлсэн; төсвийн эх үүсвэргүй	100 / 100
6	Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг	2.2.1.7	59	2025.12.04	2026–2030	Эхний шат: хэрэгжих хугацаа 2026 оноос эхэлсэн	70 / 100
В. 2026 онд батлагдсан (6), 2024–2025 оны хэрэгжилтийн үнэлгээнд хамаарахгүй							
7	Сэлэнгэ Органик хүнс	3.3.5	75	2026.01.30	2026–2031	2026 онд батлагдсан; 2025 онд «Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн»-тэй нэг мөрөөр хувиар тайлагнасан	70 / 70
8	Өдөр бүр нэг аяга сүү	2.1.1.15	76	2026.01.30	2026–2027 хичээлийн жил	2026 онд батлагдсан; батлагдахаас өмнө ХЖТ 2025-д 750.0 сая₮ төсөвлөсөн; 2 тайланд өөр хувиар	70 / 30
9	Чадварлаг эмч, чадварлаг сувилагч	2.3.2.3	77	2026.01.30	2025–2028	2026 онд батлагдсан; хэрэгжих хугацааг 2025 оноос буцаан тогтоосон	100; 70 / 70
10	Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд	4.5.1	110	2026.06.30	2026–2028	2026 онд батлагдсан; ГТ-ний 2025 оны биелэлтэд «батлагдсан» гэж тайлагнасан	30 / 30
11	Орлоготой оюутан	2.1.1.12	111	2026.06.30	2026–2028	2026 онд батлагдсан; ХЖТ 2025-д тусгаагүй	– / 90
12	Зохистой хөдөлмөр эрхлэлт	2.6.1.6	122	2026.09.25	2026–2028	2026 онд батлагдсан; 2025 онд хэрэгжилтгүй	50 / 50
II. АЙМГИЙН ИТХ-ААР БАТЛАГДААГҮЙ ХӨТӨЛБӨР (8)							
13	Ногоон Сэлэнгэ	1.1.13	–	–	2025–2028 (ҮАХ)	Батлагдаагүй; ХЖТ 2025-д нэрээр тусгаагүй, 1.1.13-ын «Тэрбум мод» ажилд 191.0 сая₮ тусгасан	– / 100

14	Сайн багш таны дэргэд	2.1.1.6	–	–	2025–2028 (YAX)	Батлагдаагүй; «Багш, сурагч солилцоо» (57/2025)-д нэгтгэгдсэн эсэх тодорхойгүй	– / 100
15	Соёлын бүтээлч үйлдвэрлэл II	2.2.1.6	–	–	2025–2028 (YAX)	Батлагдаагүй; ХЖТ-д нэг арга хэмжээгээр тайлагнасан	– / 100
16	Старт-ап	2.6.1.4	–	–	2025–2028 (YAX)	Батлагдаагүй; ХЖТ 2025-д 33.0 сая₮ төсөвлөсөн	90 / 100
17	Түрээсийн орон сууц	3.2.12	–	–	2025–2028 (YAX)	Боловсруулж байна	30 / –
18	Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн	3.3.15	–	–	2025–2028 (YAX)	ИТХ-д өргөн бариагүй (АБ-1002, ИТХ-ын хариулт), ЗДТГ-ын ХЖТ 2025-ийн тайланд «өргөн барьсан» гэж тайлагнасан; ХЖТ 2025-д «Органик хүнс»-тэй нэг мөрөөр 100.0 сая₮ төсөвлөсөн	70 / 70
19	Хог хаягдлын менежмент	3.4.6	–	–	2025–2028 (YAX)	2026 онд батлуулахаар ИТХ-д өргөн барьсан	50 / 50
20	Иргэний боловсрол	4.2.1.9	–	–	2025–2028 (YAX)	ИТХ-д өргөн бариагүй; ХЖТ 2025-д тусгаагүй	– / 100

** ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол. Эх сурвалж: ИТХ-ын 16/2025 тогтоолын хавсралт; ЗД-ын 2025.03.24-ний А/122 захирамж (АХТ); ИТХ-ын тогтоолууд (Тэргүүлэгчдийн 84/2020; 102, 120/2023; 53, 57, 58, 59/2025; 75, 76, 77, 110, 111, 122/2026); ЗДТГ-ын ХЖТ 2025, аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан; НБХ-ийн хөтөлбөрийн явцын мэдээ; «Хөтөлбөрийн түвшин тулгалт» ажлын баримт*

ИТХ-ын 2026.04.30-ны 89 дүгээр тогтоолоор аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны хэрэгжилтийг «Тодорхой үр дүнд хүрсэн» гэж үнэлж, хавсралтад 180 зорилтын хэрэгжилтийн дундаж 90.24%, өссөн дүн 33.60% гэж тусгасан; мөн өдрийн 90 дүгээр тогтоолоор аймгийн 2025 оны ХЖТ-ийн хэрэгжилтийг «Тодорхой үр дүнд хүрсэн» гэж үнэлсэн. Гэвч эдгээр үнэлгээнд 2025 онд хэрэгжээгүй болон батлагдаагүй хөтөлбөрүүдийг 30–100% гэж оруулсан (№4) тул хөтөлбөрийн бодит явцыг бүрэн илэрхийлэхгүй байна.

Хүснэгт 7 Аймгийн ЗДҮАХ 2025–2028-д тусгасан хөтөлбөрийн нэгтгэл, төрөл ба бүлгээр

Аймгийн ЗДҮАХ-ийн бүлэг	Нийт	Батлагдсан	Батлагдаагүй	Хувь, %	Батлагдсан хөтөлбөр (ИТХ-ын тогтоол)	Батлагдаагүй хөтөлбөр
А. Үндэсний хөтөлбөр (2)						
2. Хүний хөгжлийн бодлого	1	1	0	100.0	«Монгол бичгийн үндэсний хөтөлбөр–3» (ЗГ 96/2020; хугацаа дууссан)	–
4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	1	0	1	0.0	–	«Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр» (УИХ-аар батлагдаагүй)

Дүн	**2**	**1**	**1**	**50.0**		
Б. Салбарын хөтөлбөр (1)						
2. Хүний хөгжлийн бодлого	1	1	0	100.0	«Хорт хавдраас сэргийлэх, хянах» (ЭМС-ын А/241/2025)	–
Дүн	**1**	**1**	**0**	**100.0**		
В. Орон нутгийн хөтөлбөр (20)						
1. Бүсчилсэн хөгжлийн бодлого	2	1	1	50.0	«Нээлттэй Сэлэнгэ» (102/2023)	«Ногоон Сэлэнгэ»
2. Хүний хөгжлийн бодлого	12	9	3	75.0	«Нутгийн оюутан» (53/2025); «Багш, сурагч солилцоо» (57/2025); «Тоног төхөөрөмж-2» (58/2025); «Хувьсгалын өлгий нутаг» (59/2025); «Спортлог Сэлэнгэчүүд» (Тэргүүлэгчдийн 84/2020); «Сүү» (76/2026); «Чадварлаг эмч, сувилагч» (77/2026); «Орлоготой оюутан» (111/2026); «Зохистой хөдөлмөр эрхлэлт» (122/2026)	«Сайн багш таны дэргэд»; «Соёлын бүтээлч үйлдвэрлэл II»; «Старт-ап»
3. Эдийн засгийн бодлого	4	1	3	25.0	«Органик хүнс» (75/2026)	«Түрээсийн орон сууц»; «Нэг суурин – Нэг бүтээгдэхүүн»; «Хог хаягдлын менежмент»
4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	2	1	1	50.0	«Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд» (110/2026)	«Иргэний боловсрол»
Дүн	**20**	**12**	**8**	**60.0**		
Бүгд	**23**	**14**	**9**	**60.9**		

Эх сурвалж: ИТХ-ын 16/2025 тогтоолын хавсралт; «Хөтөлбөрийн түвшин тулгалт» ажлын баримт.

2.6. Хөтөлбөрийн боловсруулалтын чанар, үр дүн, үр ашиг

ИТХ-аар 2024–2025 онд батлагдсан ЗДҮАХ (16/2025) болон 6 хөтөлбөр, бодлогын баримт бичгийн (13/2024; 44, 53, 57, 58, 59/2025) боловсруулалтыг 5 шалгуураар үнэлэхэд бодлогын уялдааны хувьд бүгд хангалттай боловч шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшний хувьд аль нь ч бүрэн хангаагүй байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8 ИТХ-аар батлагдсан ЗДҮАХ (16/2025) болон 6 хөтөлбөр, бодлогын баримт бичгийн боловсруулалтын үнэлгээ, тоогоор

Үнэлгээний шалгуур	Хангалттай	Хэсэгчлэн	Хангалтгүй
1. Шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшин	0	4	3
2. Цаг үеэ олсон эсэх	1	3	3
3. Эрэлт хэрэгцээнд үндэслэсэн эсэх	1	6	0
4. Иргэдэд үзүүлэх үр нөлөө, үр дүн	1	4	2
5. Улс, аймгийн бодлоготой уялдсан эсэх	7	0	0

Эх сурвалж: ИТХ-ын 13/2024; 16, 44, 53, 57, 58, 59/2025 тогтоолын хавсралт; «нийт хөтөлбөр» тулгалтын ажлын баримт (боловсруулалтын үнэлгээ).

57/2025-д шалгуур үзүүлэлт, суурь түвшин байхгүй (зөвхөн «жил бүр 450 гаруй хүн» гэсэн хүлээгдэж буй үр дүнтэй), 59/2025-д тоон суурь, зорилтот түвшин байхгүй, 44/2025-ийнх хэмжигдэхгүй («нэмэгдүүлнэ», «тохиромжтой хэмжээнд»), 53, 58/2025, 13/2024-т суурь түвшин дутуу эсвэл жилийн зорилтгүй. 3 хөтөлбөр (53, 57, 58/2025) болон 1 бодлогын баримт бичиг (44/2025) 2025 оноос хэрэгжихээр заасан атлаа 9–12 дугаар сард батлагдсан: жишээ нь 53/2025-д тэтгэлгийн материалыг 07.15–08.15-нд авахаар заасан ч хөтөлбөр 09.30-нд батлагдсан тул 2025 онд хөтөлбөрийн тэтгэлэг олгоогүй (батлагдахаас өмнө 2.1.1.14-ээр 8.8 сая₮ олгосон), 2026 онд 23 оюутанд 115.0 сая₮ олгосон. 57, 58/2025 нь өмнөх шатны (72/2017, 60/2021) үр дүнг дүгнэлгүйгээр үргэлжилсэн. 13/2024, 44, 59/2025-ийн хугацаа 2030 он хүртэл буюу аймгийн ЗДҮАХ-ийн хугацаанаас хэтэрсэн.

Хөтөлбөрийн шууд үр дүнгийн мэдээлэл хязгаарлагдмал байна. «Тоног төхөөрөмж-2»-ын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 сургуульд 170.9 сая₮-ийн ухаалаг самбар нийлүүлсэн. Гэвч хөтөлбөрүүдэд суурь, зорилтот түвшин болон төсвийн тооцоо байхгүй тул зарцуулсан хөрөнгө, гарсан үр дүнгийн харьцааг (үр ашиг) тоон байдлаар үнэлэх боломжгүй байв.

2.7. Ололттой тал

- Аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хугацаанд (2025.03.24, А/122) батлагдсан.
- Аудитад хамрагдсан ЗДҮАХ (16/2025) болон 6 хөтөлбөр, бодлогын баримт бичиг бүгд «Алсын хараа-2050», ЗГ-ын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын хуультай уялдсан.
- «Нутгийн оюутан» хөтөлбөрт хүлээн авагчийн шалгуур, сонгон шалгаруулах журам, буцаан төлүүлэх нөхцөлийг тусгасан нь үр дүнд шууд хүргэх загвартай байна.
- ХЖТ 2024-ийн №69 арга хэмжээ (эрдэм шинжилгээний хурал) зохион байгуулагдаагүйг 0% гэж бодитоор тайлагнасан.
- Хөтөлбөрөөр олж авсан хөрөнгийн бүртгэл, биет үзлэгт (2026.11.03–04) ноцтой зөрүү илрээгүй.
- Аудитын явцад ЗДТГ эрсдэлийн удирдлагын журмыг шинэчлэн (А/47) батлагдсан.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

Илэрсэн асуудал 3.1	ИТХ-аар батлагдсан 2 бодлогын баримт бичиг, 3 хөтөлбөрт (13/2024; 44, 57, 58, 59/2025) төсөв, санхүүгийн тооцоо тусгаагүй
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: ИТХ-аар батлагдсан 2 бодлогын баримт бичиг, 3 хөтөлбөрт санхүүжилтийн зөвхөн эх үүсвэрийг жагсааж, төсвийн дүн, санхүүгийн тооцоолол тусгаагүй: Ногоон хөгжлийн бодлого-2030 (ИТХ 13/2024), ХАА-г 2030 хүртэл хөгжүүлэх бодлого (44/2025), «Багш, сурагч солилцоо» (57/2025), «Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж 2» (58/2025), «Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг» (59/2025). Төслийг ЗДТГ боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлсэн.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 20.1-д "Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.", 11.2-т "...хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, ... эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана." гэж заасан; Төсвийн тухай хуулийн 6.2.7-д "төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх." гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: Хөтөлбөрийн төсөл боловсруулах дотоод журам, загварт төсвийн тооцоо, эх үүсвэрийн задаргааг заавал хавсаргах шаардлага тусгагдаагүй; төслийг ИТХ-д өргөн барихаас өмнө СТСХ, Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулдаг урьдчилан сэргийлэх хяналт байхгүй; эрсдэлийн бүртгэлийн 21 дүгээр эрсдэлийн 12 дугаар хариу арга хэмжээ хэрэгжээгүй (№7).	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хөтөлбөрүүд тогтмол санхүүжилтгүй, ҮАХ-ийн нэгдсэн зардлаас захирамжаар хэсэгчлэн санхүүжиж (2.2), хэрэгжилт, үр дүнг төсөвтэй харьцуулан үнэлэх боломжгүй болсон.	
Зөвлөмж: Хөтөлбөрийн төсөлд арга хэмжээ тус бүрийн төсөв, эх үүсвэр, жилийн задаргааг тусгаж, СТСХ болон Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулсны дараа ИТХ-д өргөн барьж хэвшүүлэх; 13/2024; 44, 57, 58, 59/2025 тогтоолоор батлагдсан баримт бичгүүдийн төсвийн тооцоог боловсруулж, дараа жилийн төсөвт уялдуулан ИТХ-д танилцуулах. (Хүргүүлэх: ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл); хариуцах: БОНХОБТХ, НБХ, СТСХ; хугацаа: 2027.03.31, цаашид байнга) Биелэлтийг нотлох баримт: СТСХ, Хууль, эрх зүйн хэлтсийн хяналтын тэмдэглэл бүхий төсвийн тооцоотой хөтөлбөрийн төсөл; 13/2024; 44, 57, 58, 59/2025-ын төсвийн тооцоо, түүнийг ИТХ-д танилцуулсан албан бичиг.	

Илэрсэн асуудал 3.2	Тайлант хугацаанд ИТХ-аар батлагдаагүй хөтөлбөрүүдийг («Сүү», «Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд») ЗДТГ-ын 2025 оны ГТ-ний биелэлтэд «батлагдсан» гэж тайлагнасан
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: ЗДТГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд ИТХ-аар батлагдаагүй хөтөлбөрийг «батлагдсан» гэж тайлагнасан: «Өдөр бүр нэг аяга сүү» (ГТ 6.1.2, 70%) – бодитоор ИТХ-ын 2026.01.30-ны 76 дугаар тогтоолоор батлагдсан; «Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах» (ГТ 7.3.1, 100%) – 2025 онд ИТХ-аар батлагдаагүй (ИТХ-ын 2026.06.30-ны 110 дугаар тогтоолоор батлагдсан), ХЖТ 2025 №270 болон unelgee.mn-д «батлуулахаар ажиллаж байна» (30%). Хариуцсан мэргэжилтний 2025 оны ГТ-нд «Сүү»-г 9–12 сард батлуулахаар төлөвлөсөн нь биелээгүй байхад байгууллагын ГТ-нд «батлуулсан» гэж тайлагнасан; «Цэргийн насны…» хөтөлбөр эрүүл мэнд, спортын мэргэжилтний 2025 оны ГТ-нд огт тусгагдаагүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт «Байгууллагын үйл ажиллагааг дүгнэх журам»-ын 2.3-т "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжиж, үнэлэлт өгөх байдлаар хяналт-шинжилгээг хэрэгжүүлнэ.", 2.6-д "Нэгдсэн системд байршуулсан тайлангийн үнэн бодит байдлыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бүрэн хариуцна." гэж заасан; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22.4-т "Холбогдох байгууллага, албан тушаалтан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь ... шилжүүлэх үүрэгтэй." гэж заасан.	

Асуудлын үндсэн шалтгаан: ГТ-ний биелэлтийг хариуцсан мэргэжилтэн нотлох баримтгүйгээр өөрөө үнэлдэг; нэгжийн дарга, ХШҮХ нотлох баримттай тулгах 2 дахь шатны хяналт хийдэггүй; хувь хүний ГТ байгууллагын ГТ-тэй уялдаагүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Удирдлага, ЗГХЭГ болон нэгдсэн системд (unelgee.mn) бодит бус мэдээлэл хүргэж, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ хөөрөгдөх, хариуцлагын тогтолцоо сулрах эрсдэл үүссэн.
Зөвлөмж: ЗДТГ-ын ГТ-ний биелэлтийг нотлох баримттай тулгаж баталгаажуулах 2 дахь шатны хяналтыг (нэгжийн дарга, ХШҮХ) тогтоох; 2025 оны ГТ-ний биелэлтийн «батлагдсан» гэсэн үнэлгээг залруулах. (Хүргүүлэх: ЗДТГ; хариуцах: НБХ, ХШҮХ; хугацаа: 2026.12.31) Биелэлтийг нотлох баримт: 2 дахь шатны хяналтыг тогтоосон тушаал; залруулсан 2025 оны ГТ-ний биелэлт.

Илэрсэн асуудал 3.3	ЗД-ын 2025–2028 оны ҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (А/122) арга хэмжээ тус бүрийн төсөв, эх үүсвэр, жилийн задаргаа тусгаагүй
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: ЗД-ын 2025–2028 оны ҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗД-ын 2025.03.24-ний А/122 захирамжаар хугацаанд нь баталсан боловч төлөвлөгөөнд арга хэмжээ тус бүрийн төсөв, санхүүгийн тооцоо, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргааг тусгаагүй (зөвхөн шалгуур үзүүлэлт, суурь, 2025–2028 оны зорилт, хэрэгжүүлэгчийн багана бий). Аймгийн тодотгосон төсөвт «ЗДҮАХ-ийн хэрэгжилт» бөөн дүнгээр (2025 – 1,000.0 сая₮) тусгагдсан тул арга хэмжээг төсөвтэй уялдуулах боломжгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.11-д "«Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө» гэж ... Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичгийг;", 6.8.4.а-д "зорилго, зорилт, түүнийг хангахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;", 17.5-д "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ." гэж заасан; Төсвийн тухай хуулийн 6.2.7-д "төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх." гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: АХТ-г шалгуур үзүүлэлтийн хүснэгтээр боловсруулж, төсвийн тооцоог СТСХ-тэй хамтран гаргах ажлын зохион байгуулалт хийгдээгүй; аймгийн төсөвт «ЗДҮАХ-ийн хэрэгжилт» бөөн дүнгээр батлагддаг.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Захирамж бүрийг АХТ-ийн арга хэмжээ, төсөвтэй уялдуулах боломжгүй, ҮАХ-ийн 1,000.0 сая₮-ийн зардлыг заалт хооронд дураар хуваарилах эрсдэл бий болсон (2.2).	
Зөвлөмж: АХТ-г арга хэмжээ тус бүрийн төсөв, эх үүсвэр, жилийн задаргаатай болгож шинэчлэн батлах; аймгийн жилийн төсөвт аймгийн ЗДҮАХ-ийн зардлыг хөтөлбөр, арга хэмжээгээр задлан тусгах. (Хүргүүлэх: ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл); хариуцах: БОНХОБТХ, СТСХ; хугацаа: 2027.03.31) Биелэлтийг нотлох баримт: төсөв, эх үүсвэр, жилийн задаргаатай болгож шинэчилсэн АХТ-г баталсан захирамж; аймгийн ЗДҮАХ-ийн зардлыг хөтөлбөр, арга хэмжээгээр задалсан 2027 оны төсөв.	

Илэрсэн асуудал 3.4	ХЖТ болон аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайланд ИТХ-ын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зөрүүтэй, нотолгоогүй үнэлсэн
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: ЗДТГ-ын 2025 оны хэрэгжилтийн тайлангууд (ХЖТ, аймгийн ЗДҮАХ)-ыг зөрүүтэй үнэлсэн байна: (а) 4 хөтөлбөрийг хоёр тайланд өөр хувиар үнэлсэн («Сүү» 70% / 30%, ИТХ 57 ба 59 – 70% / 100%, «Чадварлаг эмч» ХЖТ-д 100% ба 70% / ҮАХ-д 70%); (б) 2025.12.04-нд батлагдсан, батлагдаагүй болон ХЖТ-д тусгаагүй хөтөлбөрийг 30–100% гэж, зарим хөтөлбөрийг зорилтоос давуулан үнэлсэн; (в) «батлуулж, хэрэгжилтийг 10%-д хүргэх» зорилттой хөтөлбөрүүдийг хэрэгжилтгүйгээр 50–100% гэж үнэлсэн (Нутгийн оюутан 100%, Тоног төхөөрөмж-2 100%, батлагдаагүй «Хог хаягдал» 50% (ИТХ-ын 90/2026-д 70%), «Сүү» 70%); (г) төсөвгүй хөтөлбөрт	

231.6 сая₮ гэж эх үүсвэр, гүйцэтгэлгүй бичсэн. Дэлгэрэнгүй тоо, эх сурвалжийг «Нотолгоо-4» ажлын баримтад тусгав.
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.16-д "«нэгтгэн тайлагнах зарчим» гэж ... Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахдаа ... тухайн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хүрэх үр дүнгийнхээ хэдэн хувьд хүрсэн, хөрөнгийн эх үүсвэр, хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу хамтад нь ... тайлагнахыг;", 18.7-д "Эрх бүхий этгээд Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг энэ хуулийн 5.2.16-д заасан зарчмын дагуу нэгтгэн тайлагнах үүрэгтэй." гэж заасан; Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт «Хяналт-шинжилгээ хийх журам»-ын 2.1.5-д "өгөгдөл, мэдээлэл найдвартай, эх сурвалж тодорхой байх;", 2.1.6-д "бодитой, нотлогдохуйц байх.", 8.3-т "Нэгдсэн системд тайлан, мэдээлэл байршуулж байгаа байгууллага, албан тушаалтан мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хариуцна." гэж заасан.
Асуудлын үндсэн шалтгаан: Хэрэгжилтийн хувийг тооцох нэгдсэн аргачлал, нотлох баримтын шаардлага тогтоогоогүй; хоёр тайланг өөр нэгж, өөр хүн бөглөж, хооронд нь тулгадаггүй; хэрэгжүүлэгч агентлагуудаас баримттай тайлан авдаггүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: ИТХ, удирдлагад хөтөлбөрийн бодит хэрэгжилтээс өндөр, зөрүүтэй мэдээлэл хүргэж, шийдвэр гаргалт бодит бус мэдээлэлд суурилах эрсдэл үүссэн.
Зөвлөмж: ХЖТ, аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны тайланд ИТХ-ын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хувийг нотлох баримтад үндэслэн нэг аргачлалаар дахин тооцож залруулах; хоёр тайланг тулгаж баталгаажуулах хяналтыг тогтоох. (Хүргүүлэх: ЗДТГ; ИТХ (мэдээлэл); хариуцах: ХШҮХ, БОНХОБТХ, НБХ; хугацаа: 2026.12.31) Биелэлтийг нотлох баримт: залруулсан ХЖТ, аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны тайлан; хэрэгжилтийн хувийг тооцох нэгдсэн аргачлалыг баталсан тушаал.

Илэрсэн асуудал 3.5	Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанаас 6 сар гаруй хоцорч (ИТХ-ын 2025.04.10-ны 22 дугаар тогтоол) баталсан
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг ИТХ-ын 2025.04.10-ны 22 дугаар тогтоолоор баталсан нь хуульд заасан хугацаанаас (2024.10.01) 6 сар гаруй хоцорсон. Иймээс 2025 оны 1 дүгээр сарын 01-ээс 4 дүгээр сарын 10-ны хооронд аймаг батлагдсан ХЖТ-гүй ажилласан. ЗДТГ нь ХЖТ-ийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.5-д заасан хугацаанд (9 дүгээр сарын 01-ний дотор) боловсруулж ИТХ-д хүргүүлсэн эсэхийг нотлох албан бичгийг аудитад ирүүлээгүй. ЗДТГ нь энэ асуудлыг нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.5-д "Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна.", 18.6-д "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална." гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: ХЖТ-ийн төсөл боловсруулах хуваарь, хариуцагчийг тушаалаар тогтоогоогүй; төслийг ИТХ-д хүргүүлсэн огноог баримтжуулдаггүй.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: 2025 оны 1–4 дүгээр сард аймаг батлагдсан ХЖТ-гүй ажилласан тул тухайн хугацааны арга хэмжээ, санхүүжилт төлөвлөгөөтэй уялдаагүй.	
Зөвлөмж: ХЖТ-ийн төслийг 09.01-ний дотор боловсруулж ИТХ-д хүргүүлэх хуваарь, хариуцагчийг тушаалаар тогтоож, хүргүүлсэн огноог баримтжуулах; ИТХ-ын Ажлын албатай хамтран 10.01-ний дотор батлуулах. (Хүргүүлэх: ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл); хариуцах: БОНХОБТХ; хугацаа: 2027.06.30) Биелэлтийг нотлох баримт: хуваарь, хариуцагч тогтоосон тушаал; дараагийн ХЖТ-ийн төслийг ИТХ-д хүргүүлсэн албан бичиг (огноо, дугаар).	

Илэрсэн асуудал 3.6	ИТХ-аар баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй

Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: ИТХ-аар баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй: ХЖТ 2024 №121-д «ИТХ-аар батлагдсан 8 дэд хөтөлбөрт ХШҮ хийж, 2025 онд ИТХ-аар хэлэлцүүлнэ» гэж төлөвлөж 70% гэж тайлагнасан боловч ХШҮ хариуцсан нэгж ийм ХШҮ хийгээгүй (АБ-1005, 5 дугаар асуулт); ХШҮ хийгдээгүй нь асуумжаар нотлогдсон бөгөөд хөтөлбөр тус бүрийн ХШҮ-ний тайлан, удирдлагын зөвлөл болон ИТХ-д хэлэлцүүлсэн баримт байхгүй.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21.3-т "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:" гэж заасан; Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт «Хяналт-шинжилгээ хийх журам»-ын 4.4.2-т "бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;" гэж заасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: ХШҮХ-ийн жилийн төлөвлөгөөнд ИТХ-ын тогтоол, хөтөлбөрийг тусгаагүй; ХШҮ-ний тайланд зөвхөн үндэсний шийдвэрүүд хамрагддаг; ХЖТ 2024 №121-ийн биелэлтийг нотолгоогүйгээр 70% гэж үнэлсэн.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хөтөлбөрүүдийн явц, үр дүнг баримтаар үнэлээгүй тул ИТХ-д тайлагнасан хувь нотолгоогүй (№4), алдааг цаг тухайд нь засах боломж алдагдсан.	
Зөвлөмж: ИТХ-аар баталсан хөтөлбөр бүрийг ХШҮХ-ийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу ХШҮ хийж, удирдлагын зөвлөл болон ИТХ-д хэлэлцүүлэх. (Хүргүүлэх: ЗДТГ; ИТХ (мэдээлэл); хариуцах: ХШҮХ; хугацаа: 2027.01.31) Биелэлтийг нотлох баримт: ИТХ-ын хөтөлбөрийг тусгасан ХШҮХ-ийн 2027 оны төлөвлөгөө; хөтөлбөр тус бүрийн ХШҮ-ний тайлан, удирдлагын зөвлөл, ИТХ-д хэлэлцүүлсэн тэмдэглэл.	

Илэрсэн асуудал 3.7	ЗДТГ-т эрсдэлийн удирдлага хэрэгжээгүй (эрсдэлийн бүртгэлийн №21, хариу арга хэмжээ №12)
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: ЗДТГ-т эрсдэлийн удирдлага хэрэгжээгүй: 2018 оны «Эрсдэлийн удирдлагын журам» (ЧМТ-6-4)-ын эрсдэлийн бүртгэлийн №21 «ИТХ-ын хөтөлбөр төсөвгүйгээс хэрэгжилт муу» (оноо 6) эрсдэлд хариу арга хэмжээний төлөвлөгөөний №12-оор «батлахдаа шаардагдах төсвийг тооцох» арга хэмжээ төлөвлөсөн боловч 2024–2025 онд батлагдсан 13/2024; 44, 57, 58, 59/2025 дугаар тогтоолд хэрэгжүүлээгүй; эрсдэлийн бүртгэлийг шинэчлээгүй, хэрэгжилтийг тайлагнаагүй; шинэ журмыг 2026.10.28-нд А/47-оор баталсан (АБ-1004). ЗДТГ нь энэ асуудлыг нотлох баримтаар хүлээн зөвшөөрсөн.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: ЗДТГ-ын Эрсдэлийн удирдлагын журам (ЧМТ-6-4, 2018)-ын эрсдэлийн бүртгэлийн 21-д "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан бодлогын баримт бичгүүд төсөв санхүүгийн улмаас хэрэгжилт муу байх" (хариу үйлдэл: "Бууруулах"), эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний 12-т "Хөтөлбөрүүдийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хөтөлбөр батлуулахдаа шаардлагатай төсвийг тооцоолж батлуулж байх" (хариуцах: "Бодлогын хэлтсүүд", хугацаа: "Жилдээ") гэж тусгасан.	
Асуудлын үндсэн шалтгаан: 2018 оны журмаар эрсдэлийн бүртгэл үүсгэсэн боловч эрсдэлийн эзэн, хэрэгжилтийн тайлагнал, жил бүрийн шинэчлэлийг хэрэгжүүлээгүй; шинэ журам 2026.10.28-нд (А/47) батлагдсан.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Таньсан эрсдэл (хөтөлбөр төсөвгүй батлагдах) бодитоор үүсэж (№1, №3), урьдчилан сэргийлэх боломж алдагдсан.	
Зөвлөмж: А/47 журмын дагуу эрсдэлийн бүртгэлийг шинэчилж, эрсдэл бүрт эзэн, хариу арга хэмжээ, хугацааг тогтоож, хэрэгжилтийг жил бүр удирдлагын зөвлөлд тайлагнах. (Хүргүүлэх: ЗДТГ; хариуцах: ЗДТГ-ын дарга; хугацаа: 2027.01.31) Биелэлтийг нотлох баримт: шинэчилсэн эрсдэлийн бүртгэл, эрсдэлийн эзэн тогтоосон тушаал, хариу арга хэмжээний хэрэгжилтийн тайлан.	

4. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар 7 асуудал илэрсэн бөгөөд бүгд дүнгээр илэрхийлэгдэхгүй төлөвлөлт, санхүүжилт, тайлагнал, дотоод хяналтын дутагдал байна. Асуудал бүрт

зөвлөмжийн шийдвэр гаргаж, хүргүүлэх байгууллагыг тодорхойлж (Хүснэгт 9, 11), арилгах арга зам, хуваарийг 6 дугаар бүлэгт тодорхойлов.

Хүснэгт 9 Илэрсэн асуудал, шийдвэрлэлтийн нэгтгэл, мянган₮

№	Илэрсэн асуудал	Дүн	Шийдвэр	Хариуцах нэгж	Хүргүүлэх
1	ИТХ-аар баталсан 2 бодлогын баримт бичиг, 3 хөтөлбөрт (13/2024; 44, 57, 58, 59/2025) төсөв, санхүүгийн тооцоо тусгаагүй	–	Зөвлөмж	БОНХОБТХ, НБХ, СТСХ	ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл)
2	Тайлант хугацаанд ИТХ-аар батлагдаагүй хөтөлбөрүүдийг («Сүү», «Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд») ЗДТГ-ын 2025 оны ГТ-ний биелэлтэд «батлагдсан» гэж тайлагнасан	–	Зөвлөмж	НБХ, ХШҮХ	ЗДТГ
3	ЗД-ын 2025–2028 оны УАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (А/122) арга хэмжээ тус бүрийн төсөв, эх үүсвэр, жилийн задаргаа тусгаагүй	–	Зөвлөмж	БОНХОБТХ, СТСХ	ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл)
4	ХЖТ болон аймгийн ЗДҮАХ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайланд ИТХ-ын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зөрүүтэй, нотолгоогүй үнэлсэн	–	Зөвлөмж	ХШҮХ, БОНХОБТХ, НБХ	ЗДТГ; ИТХ (мэдээлэл)
5	Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанаас 6 сар гаруй хоцорч (ИТХ-ын 2025.04.10-ны 22 дугаар тогтоол) баталсан	–	Зөвлөмж	БОНХОБТХ	ЗДТГ; Засаг дарга; ИТХ (мэдээлэл)
6	ИТХ-аар баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй	–	Зөвлөмж	ХШҮХ	ЗДТГ; ИТХ (мэдээлэл)
7	ЗДТГ-т эрсдэлийн удирдлага хэрэгжээгүй (эрсдэлийн бүртгэлийн №21, хариу арга хэмжээ №12)	–	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга	ЗДТГ
	Нийт		Зөвлөмж 7		ЗДТГ 7, Засаг дарга 3, ИТХ 5

5. ДҮГНЭЛТ

Аудитын зорилгын хүрээнд аймгийн ЗДҮАХ 2025–2028-д ИТХ-аар батлахаар тусгасан хөтөлбөрүүдийн батлалт, хэрэгжилтийн явц, санхүүжилт, тайлагнал, хяналтыг үнэлж дараах дүгнэлтэд хүрэв.

5.1. Хөтөлбөрийн батлалт

ЗДҮАХ-ийн хугацааны тал өнгөрөхөд (2026.11) ИТХ-аар батлах 20 хөтөлбөрийн 12 нь (60.0%) батлагдаж, 8 нь (40.0%) батлагдаагүй байна. Батлагдаагүй 8 хөтөлбөрийн 1-ийг ИТХ-д өргөн барьсан, 1-ийг боловсруулж байгаа бөгөөд 6-г ИТХ-д өргөн бариагүй (үүнээс «Старт-ап», «Ногоон Сэлэнгэ»-г ХЖТ-ээр хэсэгчлэн хэрэгжүүлж байна). 2025–2026 онд 10 хөтөлбөр батлагдсан хурдаар үлдсэн 8 хөтөлбөрийг 2027 оны I хагаст батлуулахгүй бол хэрэгжих хугацаа 1.5 жилээс богино болж, ЗДҮАХ-ийн холбогдох зорилтод хүрэхгүй байх эрсдэлтэй (Хүснэгт 5, 6).

5.2. Хэрэгжилтийн явц

2025 онд хүчин төгөлдөр байсан 6 хөтөлбөрөөс санхүүжилт авч хэрэгжиж байсан нь 2024 оноос өмнө батлагдсан 2 («Спортлог Сэлэнгэчүүд», «Нээлттэй Сэлэнгэ») бөгөөд 2025 онд батлагдсан 4 хөтөлбөр 9–12 дугаар сард батлагдсан тул 2026 оноос хэрэгжиж эхэлсэн, 2026 онд батлагдсан 6 хөтөлбөр эхний шатандаа байна. Гэтэл ЗДТГ 2025 оны ХЖТ, ЗДҮАХ-ийн тайланд хэрэгжээгүй болон батлагдаагүй 18 хөтөлбөрийг 30–100% гэж тайлагнасан (№2, №4) нь бодит явцыг хэтрүүлэн харуулж, ИТХ-ын шийдвэр гаргалтад буруу мэдээлэл өгөх эрсдэл үүсгэж байна.

5.3. Санхүүжилт

ЗДҮАХ-ийн зардлыг аймгийн төсөвт хөтөлбөрөөр задлалгүй бөөн дүнгээр (2024 онд 1,228.0, 2025 онд 1,000.0, 2026 онд 2,600.0 сая₮) баталж, АХТ (А/122) болон ИТХ-ын хөтөлбөрт төсвийн тооцоо тусгаагүй (№1, №3) тул 2025 онд ЗДҮАХ-ийн зардлаас зарцуулсан 981.9 сая₮-ийн 217.7 сая₮ (22.2%)-ийг л ИТХ-ын хөтөлбөрийн заалтаар холбож тооцох боломжтой байсан бөгөөд үүний 53.5 сая₮-ийг ЗДҮАХ-ийн хэд хэдэн заалтад үндэслэсэн захирамжаар олгосон. ХЖТ 2025-ийн хэрэгжилтийн тайланд (90/2026) 6 хөтөлбөрт төлөвлөсөн 1,146.6 сая₮-ийн 49.5 сая₮ (4.3%)-ийн гүйцэтгэл тайлагнасан атлаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг 30–100% гэж үнэлсэн. 2026 оны ХЖТ-д 11 хөтөлбөрт 2,383.1 сая₮ төлөвлөсөн боловч батлагдсан 12 хөтөлбөрийн 4-т («Нээлттэй Сэлэнгэ» (хөтөлбөрийн хүрээнд зөвхөн улсын төсвийн 553.9 сая₮-ийн Алтанбулаг чөлөөт бүсийн гаалийн хяналтын арга хэмжээ тусгасан), «Органик хүнс», «Орлоготой оюутан», «Зохистой хөдөлмөр эрхлэлт») орон нутгийн төсвөөс санхүүжилт тусгаагүй тул батлагдсан хөтөлбөр ч хэрэгжилтгүй үлдэх эрсдэлтэй (Хүснэгт 2).

5.4. Тайлагнал, хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлага

ИТХ-ын хөтөлбөрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй (№6), эрсдэлийн бүртгэлийн хариу арга хэмжээ хэрэгжээгүй (№7), ХЖТ-ийг хуулийн хугацаанаас хоцорч баталсан (№5) нь дээрх дутагдлыг цаг тухайд нь илрүүлж засах боломжийг хязгаарласан. Үндсэн шалтгаан нь хөтөлбөрийн төлөвлөлт, санхүүжилт, тайлагналын үе шатыг холбох нэгдсэн хариуцагч, төсвийн задаргаа, тайлангийн 2 дахь шатны тулгалт тогтоогдоогүйд оршино.

Аудитаар илэрсэн 7 асуудлын 4 нь «Нөлөө их», 3 нь «Нөлөө дунд» ангилалд хамаарч, засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын төлөвшил 2 дугаар түвшинд байгаа тул дээрх нөхцөл байдалд үндэслэн «Сайжруулах шаардлагатай» гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшил давтамжтай буюу 2 дугаар түвшинд байна гэж үзсэн (засаглалын бүтэц, хариуцлагын хуваарилалт III; дотоод хяналтын бусад элемент, мэдээлэл дамжуулалт, мониторинг, эрсдэлийн удирдлага I түвшин). Аудитаар илэрсэн 7 асуудлын 4 буюу 57.1 хувь нь **«Нөлөө их»** ангилалд хамаарч байгаа нь 21–79 хувийн хязгаарт багтаж байна.

6. ЗӨВЛӨМЖ

Аймгийн ЗДҮАХ-ийн үлдсэн хугацаанд (2027–2028) ИТХ-аар батлах хөтөлбөрүүдийг бүрэн шийдвэрлэж, батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжилт, тайлагналтай нь уялдуулан хангах зорилгоор дараах зөвлөмжийг үе шаттай хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

6.1. Батлагдаагүй 8 хөтөлбөрийг шийдвэрлэх (2026.12–2027.06)

Батлагдаагүй хөтөлбөр тус бүрээр батлуулах, батлагдсан хөтөлбөрт нэгтгэх, эсхүл ЗДҮАХ-д өөрчлөлт оруулах шийдвэрийг хөтөлбөр тус бүрийн одоогийн байдалд (Хүснэгт 6) үндэслэн гаргаж, ЗДҮАХ-д өөрчлөлт оруулах бол ИТХ-аар батлуулах (№1, №2; хариуцах: БОНХОБТХ, НБХ, холбогдох агентлаг).

6.2. Батлагдсан 12 хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжилттэй уялдуулах (2027 оны төсөв, ХЖТ)

- 2027 оны аймгийн төсөвт ЗДҮАХ-ийн зардлыг бөөн дүнгээр бус хөтөлбөр, арга хэмжээгээр задалж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөтөлбөр тус бүрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тусгах; ИТХ-ын 56/2025 тогтоолын нэгдүгээр хавсралтын 15.1-д «2026–2030» гэж буруу бичсэн ЗДҮАХ-ийн хугацааг залруулах (№1, №3; хариуцах: СТСХ, БОНХОБТХ; хугацаа: 2027 оны төсвийг батлуулахаас өмнө).
- 2026 оны ХЖТ-д орон нутгийн төсвөөс санхүүжилт тусгаагүй «Нээлттэй Сэлэнгэ», «Органик хүнс», «Орлоготой оюутан», «Зохистой хөдөлмөр эрхлэлт» хөтөлбөрийн 2027 оны санхүүжилтийн дүн, эх үүсвэрийг тодорхойлж, ХЖТ, төсөвт тусгах (№1; хариуцах: БОНХОБТХ, НБХ, ХХААГ, ХХҮГ; хугацаа: цаашид).
- А/122 АХТ-ийг шинэчилж ИТХ-ын хөтөлбөр бүрийн арга хэмжээ, төсөв, эх үүсвэр, жилийн задаргаа, хариуцагчийг тусгах; ЗД-ын захирамжаар ЗДҮАХ-ийн зардлаас санхүүжүүлэхдээ хөтөлбөрийн арга хэмжээ, шалгуурыг заавал дурдаж, хөтөлбөрт хамааралгүй нэг удаагийн зардлыг хязгаарлах (№3; хариуцах: БОНХОБТХ, Хууль, эрх зүйн хэлтэс; хугацаа: 2027.03.31).
- 2025–2026 онд батлагдсан 10 хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний жилийн суурь, зорилтот түвшинг тогтоож, хугацаа нь ЗДҮАХ-аас хэтэрсэн («Сэлэнгэ – хувьсгалын өлгий нутаг», «Органик хүнс» г.м.) хөтөлбөрийн 2028 он хүртэлх завсрын зорилтыг тодорхойлох (№1; хариуцах: хөтөлбөр хариуцсан нэгж; хугацаа: 2027.03.31).

6.3. Тайлагнал, хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлагыг сайжруулах

- ГТ, ХЖТ, ЗДҮАХ-ийн биелэлтийг нэг аргачлалаар, нотлох баримтад үндэслэн тооцож, батлагдаагүй эсвэл санхүүжилтгүй хөтөлбөрийг «хэрэгжээгүй» гэж тайлагнах; нэгтгэгчээс өөр албан тушаалтнаар тулгаж баталгаажуулах; 2025 оны тайлангийн зөрүүг залруулах (№2, №4; хариуцах: ХШҮХ, БОНХОБТХ, НБХ; хугацаа: 2026.12.31).
- ХЖТ-ийн төслийг жил бүрийн 09.01-ний дотор боловсруулж ИТХ-д хүргүүлэх хуваарь, хариуцагчийг тушаалаар тогтоож, 10.01-ний дотор батлуулах (№5; хариуцах: БОНХОБТХ; хугацаа: 2027.06.30, цаашид жил бүр).
- ИТХ-ын хөтөлбөр бүрийг ХШҮХ-ийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, дүнг удирдлагын зөвлөл, ИТХ-д хэлэлцүүлэх; А/47 журмын дагуу эрсдэлийн

бүртгэлийг шинэчилж, эрсдэлийн эзэн, хариу арга хэмжээг тогтоох (№6, №7; хариуцах: ХШҮХ, ЗДТГ-ын дарга; хугацаа: 2027.01.31).

- ИТХ-ын тогтоол бүрт хариуцагч нэгж, шууд хэрэгжүүлэгч, тайлагнах давтамжийг ЗДТГ-ын даргын тушаалаар оноож, агентлагуудаас баримттай тайлан авах (№2, №4, №6; хариуцах: ЗДТГ-ын дарга; хугацаа: 2027.01.31).

6.4. Хэрэгжилтийн явцын хяналт

ЗДТГ нь аймгийн ЗДҮАХ-д тусгасан 20 хөтөлбөрийн батлалт, санхүүжилт, хэрэгжилтийн явцыг Хүснэгт 2, 6-гийн загвараар улирал бүр шинэчилж ЗД-ын зөвлөлөөр, хагас жил тутам ИТХ-д танилцуулах; 2027 оны III улиралд ЗДҮАХ-ийн дунд хугацааны үнэлгээ хийж, үлдсэн хугацааны хэрэгжилтийн төлөвлөгөөг шинэчлэх (№4, №6; хариуцах: ХШҮХ, БОНХОБТХ; хугацаа: 2027.01.31-ээс улирал бүр).

Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд нотлох баримтын хамт Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэх бөгөөд газраас зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хяналт (АБ-5000) хийнэ. Зөвлөмж бүрийн биелэлтийг 3 дугаар бүлэгт заасан «биелэлтийг нотлох баримт»-аар үнэлж, бүрэн биелсэн, хэсэгчлэн биелсэн, биелээгүй гэж дүгнэнэ.

6.5. Зөвлөмж хүргүүлэх байгууллага

Аудитын дүгнэлт (5 дугаар бүлэг), илэрсэн асуудал (3.1–3.7) болон 6.1–6.4-т заасан зөвлөмжийг тухайн байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэгт нийцүүлэн доорх байгууллагуудад тайлангийн хамт албан бичгээр хүргүүлнэ (Хүснэгт 10). ИТХ-ын үйл ажиллагаа аудитын хамрах хүрээнд хамаараагүй тул ИТХ-д мэдээлэл, санал хэлбэрээр хүргүүлнэ.

Хүснэгт 10 Зөвлөмж хүргүүлэх байгууллага, үндэслэл

№	Хүргүүлэх байгууллага	Хамаарах асуудал, зөвлөмж	Хүргүүлэх үндэслэл, хэлбэр	Тайлангийн хэсэг
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар (дарга Ө.Сувдаа)	№1–№7 бүх зөвлөмж; батлагдаагүй 8 хөтөлбөрийг шийдвэрлэх; ХЖТ 2026-д санхүүжилтгүй 4 хөтөлбөрийн 2027 оны санхүүжилт	Аудитад хамрагдсан байгууллага. Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг даргын тушаалаар батлан 2026.12.01-ны дотор ирүүлэх; биелэлтийг нотлох баримтын хамт заасан хугацаанд ирүүлэх	3.1–3.7; 5.1–5.4; 6.1–6.4; Хүснэгт 9
2	Аймгийн Засаг дарга	№1, №3, №5: АХТ (А/122)-г шинэчлэх; 2027 оны төсвийн төсөлд ЗДҮАХ-ийн зардлыг задлах, ИТХ-ын 56/2025-ын 15.1-ийг залруулах; ЗД-ын захирамжийн шаардлага; батлагдаагүй хөтөлбөрийн талаар ИТХ-д санал өргөн мэдүүлэх	Удирдамж баталсан этгээд. Засаг даргын эрх хэмжээнд хамаарах зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, ЗДТГ-т арга хэмжээний төлөвлөгөө батлуулахыг даалгах	2.2; 3.1, 3.3, 3.5; 5.1, 5.3; 6.1, 6.2
3	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Тэргүүлэгчид)	№1, №3, №4, №5, №6: хөтөлбөрийн төслийг төсвийн тооцоотой хүлээн авах; залруулсан 2025 оны тайлан авах; ХЖТ-ийн хуваарь; батлагдаагүй 8 хөтөлбөр; ХШҮ-ний дүнг сонсох; 2027 оны төсвийг батлахаас өмнө авах арга хэмжээ	ИТХ-ын үйл ажиллагаа аудитын хамрах хүрээнд хамаараагүй тул мэдээлэл, санал хэлбэрээр; ИТХ-аар баталсан хөтөлбөр, ИТХ-д тайлагнасан мэдээлэлтэй холбоотой	1.4; 2.2, 2.5; 3.1, 3.4–3.6; 5.2, 5.3; 6.1, 6.2, 6.4

Эх сурвалж: тайлангийн 1.4, 3, 5, 6 дугаар бүлэг, Хүснэгт 9; ДА-2026/13/УА удирдамж; Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026.11.18-ны тайлан хүргүүлэх албан бичгүүд.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах нэгж, хугацаа, нотлох баримтыг 3 дугаар бүлэгт, хүргүүлэх байгууллагыг Хүснэгт 9, 10-д заасан бөгөөд эргэн хяналтыг (АБ-5000) хүргүүлсэн байгууллага тус бүрээр хийнэ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР Г.ДОРЖДЭРЭМ

ДОТООД АУДИТОР Б.ИДЭРЧУЛУУН

ТАЙЛАН ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА СХШУАБ Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ө.СУВДАА